



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 12 сарын 24 өдөр

Дугаар А/675

Хэрлэн сум

2025 оны цэргийн бүртгэл  
явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4 дэх заалт, Цэргийн албаны тухай хуулийн 34 дүгээр зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Цэргийн бүртгэлийг зохион байгуулах ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн

дарга: Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга

Орлогч

дарга: Цэргийн штабын дарга

Нарийн бичгийн

дарга: Цэргийн штабын тоо бүртгэлийн ахлах офицер

Гишүүдэд:

Цэргийн штабын дайчилгааны офицер

Цэргийн штабын орон нутгийн хамгаалалтын бэлтгэл,  
сургалтын офицер

Статистикийн хэлтсийн дарга

Улсын бүртгэлийн хэлтсийн дарга

Сумдын Засаг дарга

Тосгоны захирагч

2.2025 оны цэргийн бүртгэлийг 2025 оны 01 дүгээр сарын 06-ны өдрөөс 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийг дуустал зохион байгуулсугай.

3.Цэргийн бүртгэл явуулах ажлын хэсгийг холбогдох албан тушаалтнуудыг оролцуулан 5-аас доошгүй хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулж, цэргийн үүрэгтэн иргэдийг биечлэн болон цахимаар бүртгэж, 2024 оны жилийн эцсийн хүн амын тоотой тулган, цэргийн бүртгэлийн материал, мэдээ, судалгааг маягтын дагуу гаргаж, хуваарийн дагуу сумдын Засаг даргын Тамгын газрын дарга, Тосгоны Захирагчийн ажлын албаны дарга нараар хүргүүлэхийг сумдын Засаг дарга, Тосгоны захирагч нарт даалгасугай.

2.

4.Цэргийн бүртгэлийн явцад хяналт тавьж, шалган туслах хуваарийг нэгдүгээр, сумдын цэргийн бүртгэлийн материал тушаах хуваарийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

5.Цэргийн бүртгэлийн явцын байдалд заавар зөвлөмж өгөх, илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээ авах, цэргийн бүртгэлийн материалыг тогтоосон хугацаанд сумдаас хүлээн авч зааврын дагуу нэгтгэж, нэгдсэн дүн мэдээг 2025 оны 2 дугаар сарын 25-ны дотор Зэвсэгт хүчний Жанжин штабт хүргүүлэхийг ажлын хэсгийн дарга (Ж.Гантулга)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.АЮУРБУНЬ

Аймгийн Засаг даргын 2024 оны  
 А/675/12 дугаар сарын 29 -ний өдрийн  
 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

**2025 ОНЫ ЦЭРГИЙН БҮРТГЭЛИЙН ЯВЦТАЙ  
ТАНИЛЦАЖ, ШАЛГАН ЗААВАРЛАХ ХУВААРЬ**

д/д	Сумдын нэр	Шалган туслах хуваарь	Он, сар, өдөр
1	Баянхутаг	Дэд хурандаа Л.Цэнддорж	2025.01.07
2	Бор-Өндөр		2025.01.07-08
3	Дархан		2025.01.08
4	Баянмөнх		2025.01.09
5	Дэлгэрхаан		2025.01.09
6	Цэнхэрмандал		2025.01.10
7	Жаргалтхаан		2025.01.10
8	Бэрх		2025.01.13
9	Батноров		2025.01.13-14
10	Норовлин		2025.01.15
11	Дадал		2025.01.16
12	Хэрлэн 1-р баг	Дэд хурандаа Г.Батгэрэл	2025.01.06
13	Хэрлэн 2-р баг		
14	Хэрлэн 3-р баг		2025.01.20
15	Хэрлэн 4-р баг		
16	Хэрлэн 5-р баг		
17	Хэрлэн 6-р баг		

Аймаг Засаг даргын 2024 оны  
 дугаар сарын 25-ний өдрийн  
 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

А/1675/25

**2025 ОНЫ ЦЭРГИЙН БҮРТГЭЛИЙН  
МАТЕРИАЛ ТУШААХ ХУВААРЬ**

д/д	Сумдын нэр	Он, сар, өдөр	Цаг	Хариуцах эзэн
1	Мөрөн	2025.01.22	09.00	Тамгын газрын дарга
2	Жаргалтхаан		12.00	Тамгын газрын дарга
3	Цэнхэрмандал		15.00	Тамгын газрын дарга
4	Бэрх		18.00	Захирагчийн ажлын албаны дарга
5	Баянхутаг	2025.01.23	09.00	Тамгын газрын дарга
6	Галшар		12.00	Тамгын газрын дарга
7	Бор-Өндөр		15.00	Тамгын газрын дарга
8	Дархан		18.00	Тамгын газрын дарга
9	Баянмөнх	2025.01.24	09.00	Тамгын газрын дарга
10	Дэлгэрхаан		12.00	Тамгын газрын дарга
11	ХБУлаан		15.00	Захирагчийн ажлын албаны дарга
12	Баян-Овоо		18.00	Тамгын газрын дарга
13	Өмнөдэлгэр	2025.01.25	09.00	Тамгын газрын дарга
14	Гурванбаян		12.00	Захирагчийн ажлын албаны дарга
15	Батширээт		15.00	Тамгын газрын дарга
16	Биндэр		18.00	Тамгын газрын дарга
17	Дадал	2025.01.26	09.00	Тамгын газрын дарга
18	Норовлин		12.00	Тамгын газрын дарга
19	Батноров		15.00	Тамгын газрын дарга
20	Баян-Адарга		18.00	Тамгын газрын дарга
21	Өлзийт	2025.01.27	09.00	Захирагчийн ажлын албаны дарга
22	Хэрлэн 1-р баг		12.00	Багийн Засаг дарга
23	Хэрлэн 2-р баг		15.00	Багийн Засаг дарга
24	Хэрлэн 3-р баг		18.00	Багийн Засаг дарга
25	Хэрлэн 4-р баг	2025.01.28	09.00	Багийн Засаг дарга
26	Хэрлэн 5-р баг		12.00	Багийн Засаг дарга
27	Хэрлэн 6-р баг		15.00	Багийн Засаг дарга
28	Хэрлэн 8-р баг		18.00	Багийн Засаг дарга